



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ГАДААД СУВГИЙН ТАЙЛАН

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

2025

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад олон суваг дамжуулах үйлчилгээ (ОСДҮ) нь мэдээллийн хүртээмж, олон улсын контентын сонголтыг өргөжүүлэхэд чухал үүрэгтэй салбар болон хөгжсөөр байна. Иргэдийн гадаад сувгийн эрэлт тасралтгүй өсөж, контентын төрөлжилт нэмэгдэхийн хэрээр үйлчилгээний чанар, хэрэглэгчийн эрхийг хангах асуудал илүү ач холбогдолтой болсон.

Энэхүү тайлан нь зөвхөн хууль эрх зүйн шаардлагыг биелүүлээд зогсохгүй хэрэглэгчдэд хүрч буй олон улсын телевизийн сувгийн бодит тоо хэмжээ, хөтөлбөрийн төрөл, хэлний сонголт зэрэг салбарын хөгжлийн үндсэн үзүүлэлтийг ил тод харуулах ач холбогдолтой юм.

Энэ оны тайлан нь 2024 онд бүртгэгдсэн мэдээллийг суурь болгон авч, тухайн ондоо гарсан гол өөрчлөлт, чиг хандлагыг нарийвчлан тусгасан. Үүнд:

- **Үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний өөрчлөлт** – тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагаагаа зогсоосон үйлчилгээ эрхлэгчид, дамжуулж буй сувгийн тооны өсөлт бууралт.
- **Гадаад сувгийн бүтэц, хэл, хөтөлбөрийн төрөл** – хэрэглэгчдийн эрэлт, сувгийн төрөлжилт, олон улсын сувгийн харьяалал.
- **Технологи** –SD болон HD форматын харьцаа.
- **Гэрээний хэрэгжилт** – эрх бүхий үйлчилгээ эрхлэгчдийн гадаад сувгийг дамжуулах гэрээний тоо, гэрээгүй дамжуулалтын түвшин.

Жил бүрийн тоон өөрчлөлт, шинэчлэлийг анхааран шинжлэх нь зөвхөн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дүгнэхээс гадна өргөн нэвтрүүлгийн салбарын цаашдын хөгжилд чиглэл өгөх чухал ач холбогдолтой.

1.ГАДААД СУВАГ БҮРТГЭСЭН ТУХАЙ

Өмнөх 2024 онд Монгол Улсад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй 30 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч байсан бол энэ тоо 27 болж үйлчилгээ эрхлэгчийн тоо цөөрсөн ба эдгээр үйлчилгээ эрхлэгчдийг хамрах хүрээгээр нь авч үзэхэд Монгол Улсад хамрах хүрээтэй - 6, Улаанбаатар хот болон бусад бүс нутагт хамрах хүрээтэй - 6, орон нутгийн хамрах хүрээтэй - 15 үйлчилгээ эрхлэгч байна. Гадаад сувгийн 2024 оны тайлан мэдээнд 28 үйлчилгээ эрхлэгч хамрагдсан бол үүнээс 2 үйлчилгээ эрхлэгч нь өөрийн хүсэлтээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Иймд энэ жилийн тайланд 26 үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжиж байгаа гадаадын телевизийн сувгийн мэдээллийг багтаасан бөгөөд мэдээлэл ирүүлээгүй 1 үйлчилгээ эрхлэгч нь гадаад суваг дахин дамжуулдаггүй үйлчилгээ эрхлэгч юм.

Хүснэгт-1: Дамжуулж байгаа гадаадын телевизийн сувгийг үйлчилгээ эрхлэгч нэг бүрээр авч үзэхэд

№	Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Үйлчилгээний нэр	Гадаад сувгийн тоо
1	Юнивишн ХХК	Univision	82
2	Скаймедиа корпораци ХХК	Skymedia	65
3	Ддэш ТВ ХХК	Ddish	51
4	ЖСММ БГБХ Нөхөрлөл	ЖСММ КаТВ	50
5	Эн Би Си ХХК	MNBC	48
6	Дөрвөн шарга ХХК	Дөрвөн шарга КаТВ	42
7	Мобинет ХХК	VOO	36
8	Хаан алтай ховд ХХК	Хаан Алтай Ховд КаТВ	34
9	Шинэ сансар ХХК	Beyond Media	33
10	Монголсат нэтворкс ХХК	MongoISat	28
11	Монголын цахилгаан холбоо ХК	National КаТВ	28
12	Талс эрчим ХХК	Талст КаТВ	27
13	Сансар дижитал ХХК	Хөдөлгөөнт Телевиз	23
14	Цацраг трейд ХХК	Цацраг трэйд КаТВ	22
15	Оптимум нэтворкс ХХК	Оптимум КаТВ	20
16	Агаарын суваг ХХК	Агаарын суваг КаТВ	19
17	Мэргэшир-Од ХХК	Мэргэшир-Од КаТВ	16
18	Дархан ширхэнцэг ХХК	Дархан ширхэнцэг КаТВ	15
19	Өвөр даваат ХХК	Өндөр Мандал КаТВ	14
20	Гал саятан ХХК	Стар КаТВ	13
21	Эм Эм Ди Эс ХХК	Эм Эм Ди Эс КаТВ	13
22	Ди Би Эс Си ХХК	Ди Би Эс КаТВ	12
23	Би Ти Жи ХХК	Би Ти Жи КаТВ	10
24	Мөнх саран чулуун ХХК	Солонго КаТВ	10
25	Наран гүрт ХХК	ТОД caTV	9
26	Орхон систем ХХК	Орхон системс КаТВ	7

Энэ жилийн тайлан мэдээг 2025 оны хагас жилийн статистик мэдээлэлд үндэслэн гаргасан бөгөөд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч өөрийн сүлжээгээр 32 орны нийт 287, давхардсан тоогоор нийт 727 гадаад сувгийг дахин дамжуулж байна. Энэ нь 2024 оны тайланд тусгагдсан тоон мэдээлэлтэй харьцуулахад 33 суваг хасагдаж, 4%-иар буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч нэг үйлчилгээ эрхлэгчид ноогдох дундаж сувгийн тоогоор авч үзэхэд 0.8%-иар өссөн байна.

Харьяалагдах улс орнуудын ангиллаар авч үзэхэд Вьетнам улсын телевизийн суваг шинээр нэмэгдэж, Унгар улсын суваг бүртгэлээс хасагдсан байна.

Үйлчилгээ эрхлэгч бүрийн суваг нэмэгдэж, хасагдсан өөрчлөлтийн хувьд 2024 онд нийт 760 гадаад суваг бүртгэгдэж байсан бол 2025 оны тайлан боловсруулах явцад 84 суваг хасагдаж, 52 суваг шинээр нэмэгдсэн байна. Хасагдсан сувгийн дийлэнх нь гэрээний хугацаа дууссан, сувгийн нийлүүлэлт зогссон зэргээс шалтгаалж байна. Харин шинээр нэмэгдсэн сувгууд нь ихэвчлэн олон улсын мэдээ, спорт, хүүхдийн болон тусгай сэдэвт контент нэвтрүүлдэг сувгууд байх ба зарим үйлчилгээ эрхлэгч зах зээлийн эрэлт, хэрэглэгчийн сонирхолд тулгуурлан сувгийн бүтцэдээ өөрчлөлт оруулсан нь дээрх тоон үзүүлэлтийн гол шалтгаан болж байна.

2. ГАДААД СУВГИЙН ЧАНАР

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжиж байгаа 727 гадаад сувгийн 526 нь стандарт тодролтой (SD) буюу нийт гадаад сувгийн 72%-ийг бүрдүүлсэн бол 201 нь өндөр тодролтой (HD) бөгөөд энэ нь нийт гадаад сувгийн 28%-ийг бүрдүүлж байна. Дээрх үзүүлэлтийг 2024 оны тоон мэдээлэлтэй харьцуулж үзэхэд SD сувгийн тоо тодорхой хэмжээнд буурч HD сувгийн тоо өссөн бөгөөд энэ нь хэрэглэгчид илүү өндөр чанартай дүрс, дууны эрэлттэй болж буйг илтгэж байна. Үүнээс үзэхэд үйлчилгээ эрхлэгчид сувгийн дүрсийн чанарт анхаарч, үе шаттай шилжиж байгааг энэхүү өөрчлөлт харуулж байна.


Хамгийн их SD суваг дамжуулж байгаа үйлчилгээ эрхлэгч нь ЖСММ БГБХ Нөхөрлөл байсан бөгөөд дамжуулж буй бүх гадаадын телевизийн суваг (50 суваг) нь SD форматтай хэрэглэгчдэд хүрч байна. Энэ нь нийт SD сувгийн 9.5%-ийг эзэлж байгаа бол Юнивишн ХХК нь 61 HD суваг дамжуулж, нийт HD сувгийн 30.3%-ийг бүрдүүлж, хамгийн их хувийг эзэлж байна. Зарим үйлчилгээ эрхлэгчид (Юнивишн ХХК, Мобинет ХХК, Сансар дижитал ХХК) HD сувгийг түлхүү дамжуулж, зах зээлд өндөр чанартай контентыг өндөр нарийвчлалтай дүрс, өргөн динамиктай дуутай контентыг үзэгчдэд санал болгож буй нь зах зээлд өрсөлдөх давуу талыг бий болгож байна.

Дийлэнх үйлчилгээ эрхлэгч дор хаяж нэг гадаад сувгийг HD форматаар дамжуулж байгаа бол 11 үйлчилгээ эрхлэгч огт HD суваг дамжуулдаггүй бөгөөд энэ нь нийт үйлчилгээ эрхлэгчдийн 42%-ийг эзэлж байна. Мөн огт гадаадын SD суваг дамжуулдаггүй 4 үйлчилгээ эрхлэгч байгаа нь нийт үйлчилгээ эрхлэгчдийн 15%-д хүрч байна. Гадаад сувгийн 2024 оны тоон мэдээлэлтэй харьцуулахад 3 үйлчилгээ эрхлэгч шинээр HD форматаар үйлчилгээ үзүүлж эхэлсэн бол SD суваг дамжуулдаггүй үйлчилгээ эрхлэгчийн тоо 1-ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

форматаар нь авч үзвэл.

№	Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Үйлчилгээний нэр	SD	HD	Гадаад сувгийн тоо
Улаанбаатар					
1	Юнивишн ХХК	Univision	21	61	82
2	Скаймедиа корпораци ХХК	Skymedia	42	23	65
3	Ддэш ТВ ХХК	Ddish	45	6	51
4	Эн Би Си ХХК	MNBC	48	-	48
5	Мобинет ХХК	VOO	6	30	36
6	Шинэ сансар ХХК	Beyond Media	25	8	33
7	Монголсат нэтворкс ХХК	MongolSat	28	-	28
8	Монголын цахилгаан холбоо ХК	National KaTV	26	2	28
0	Талс эрчим ХХК	Талст KaTV	26	1	27
10	Сансар дижитал ХХК	Хөдөлгөөнт Телевиз	-	23	23
11	Оптимум нэтворкс ХХК	Оптимум KaTV	19	1	20
Орон нутаг					
12	ЖСММ БГБХ Нөхөрлөл	ЖСММ KaTV	50	-	50
13	Дөрвөн шарга ХХК	Дөрвөн шарга KaTV	42	-	42
14	Цацраг трейд ХХК	Цацраг трэйд KaTV	21	1	22
15	Агаарын суваг ХХК	Агаарын суваг KaTV	19	-	19
16	Мэргэшир-Од ХХК	Мэргэшир-Од KaTV	6	10	16
17	Дархан ширхэнцэг ХХК	Дархан ширхэнцэг KaTV	9	6	15
18	Өвөр даваат ХХК	Өндөр Мандал KaTV	14	-	14
19	Гал саятан ХХК	Стар KaTV	13	-	13
20	Эм Эм Ди Эс ХХК	Эм Эм Ди Эс KaTV	13	-	13
21	Ди Би Эс Си ХХК	Ди Би Эс KaTV	12	-	12
22	Би Ти Жи ХХК	Би Ти Жи KaTV	-	10	10
23	Мөнх саран чулуун ХХК	Солонго KaTV	-	10	10
24	Наран гүрт ХХК	ТОД caTV	-	9	9
25	Орхон систем ХХК	Орхон системс KaTV	7	-	7
26	Хаан алтай ховд ХХК	Хаан Алтай Ховд KaTV	34	-	34
Нийт			526	201	727

График-1. Гадаад сувгийг дүрсийн форматаар нь авч үзэн хувиар илэрхийлэв.



3.ОСДҮЭ-ИЙН СҮЛЖЭЭГЭЭР ДАХИН ДАМЖИЖ БАЙГАА ГАДААД СУВАГ

Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчдийн хувьд: 2024 оны тайланд 29 улсын 11 үйлчилгээ эрхлэгчийн 438 гадаадын телевизийн суваг бүртгэгдсэн бол энэ оны тайланд Унгар улсын телевизийн суваг хасагдаж, харин Вьетнам болон Энэтхэг улсын телевизийн суваг шинээр нэмэгдэж бүртгэгдсэнээр 30 улсын 441 гадаадын телевизийн суваг бүртгэгдсэн байна. Энэ нь нийт гадаад сувгийн 61%-ийг бүрдүүлж байна. Үүнээс ОХУ-ын телевизийн суваг 138 байгаа нь Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчдийн дамжуулж буй нийт гадаад сувгийн 31%-ийг бүрдүүлж, хамгийн их хувийг эзэлж байна. Харин Вьетнам, Люксембург, Турк, Чех зэрэг улсын телевизийн сувгууд тус бүр 1 байгаа нь хамгийн бага (0.2%)-ийг эзэлж байна.


Хүснэгт-3: Улаанбаатар хотын ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад
Сувгуудыг харьяалагдах улсаар нь харуулав.

№	Харьяалагдах улс	Ддэш ТВ ХХК	Мобинет ХХК	Монголсат нэтворкс ХХК	Монголын цахилгаан холбоо ХК	Оптимум нэтворкс ХХК	Сансар дижитал ХХК	Скаймедиа корпораци ХХК	Талс эрчим ХХК	Шинэ сансар ХХК	Эн Би Си ХХК	Юнивишн ХХК	Нийт
1	Австрали							1				1	2
2	Англи		1				2	1					4
3	АНУ	11	9	1	2			10	2		2	8	45
4	Араб					2							2
5	БНКУ	4	7	1		1		1			2	3	19
6	БНСУ	2	1			2	2	3	1	2	2	3	18
7	БНХАУ	3			1	4	5	7	2	11	3	4	40
8	Болгар	1									2	1	4
9	Вьетнам											1	1
10	Герман	2	1	1	1	1	1	1	1	1	1	3	14
11	Испани							1		1			2
12	Итали						1	1		1			3
13	Их Британи	3	3	2	1	1		5			3	5	23
14	Канад	1							1		1	2	5
15	Катар		1				1	1		1	1	1	6
16	Киргизстан							1		1		1	3
17	Люксембург											1	1
18	Нидерланд			1	2								3
19	ОХУ	7	4	14	18	6	7	20	14	11	20	17	138
20	Сингапур	11		1			1	2	1	1	2	21	40
21	Словак	1									1	1	3
22	Турк										1		1
23	Украйн											3	3
24	Франц	4	2	4		2	3	5		1	5	4	30
25	Хонг Конг			1				1		1	1		4
26	Чех			1									1
27	Швед				2				4				6
28	Шинэ Зеланд		6										6
29	Энэтхэг							2					2
30	Япон	1	1	1	1	1		2	1	1	1	2	12
Нийт		51	36	28	28	20	23	65	27	33	48	82	441

Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчдээс Юнивишн ХХК нь хамгийн их суваг (82 суваг) дамжуулж, тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж буй үйлчилгээ эрхлэгчдийн дамжуулж буй гадаадын телевизийн сувгийн 18.5%-ийг бүрдүүлж байгаа бол Сансар дижитал ХХК нь 23 телевизийн суваг дамжуулж, хамгийн бага хувийг буюу 5.2%-ийг бүрдүүлж байна.

Доорх графикаас үзэхэд дийлэнх үйлчилгээ эрхлэгчдийн гадаад сувгийн тоо хэмжээ 2025 онд 2024 оныхоос өссөн эсвэл тогтвортой үзүүлэлттэй байгаа бол зарим үйлчилгээ эрхлэгчдийн сувгийн тоо цөөрсөн байгаа ч огцом бууралт харагдахгүй байна. Хамгийн их сувгийн тоог нэмэгдүүлсэн үйлчилгээ эрхлэгч нь Мобинет ХХК бөгөөд 8 суваг нэмэгдүүлж 2024 онтой харьцуулахад 8%-ийн өсөлттэй байгаа бол хамгийн их суваг хассан үйлчилгээ эрхлэгч нь Монголын цахилгаан холбоо ХК бөгөөд 5 суваг хасаж, 15%-иар буурсан үзүүлэлттэй байна.

График-4. Улаанбаатар хотын ҮЭ-н дамжуулж буй гадаадын телевизийн сувгийг 2024 оны тоон мэдээлэлтэй харьцуулсан дүн.



Орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд: 2024 оны тайлангаар 17 үйлчилгээ эрхлэгчийн 24 улсын нийт 322 гадаад телевизийн суваг бүртгэгдсэн. Харин 2025 онд Украин болон Чех улсын сувгууд хасагдсанаар 15 үйлчилгээ эрхлэгчийн 22 улсын 286 суваг бүртгэгдсэн. Энэ нь нийт гадаад сувгийн 39%-ийг эзэлж байна. Үүнээс ОХУ-ын сувгууд 126-д хүрч, орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн дамжуулж буй гадаад сувгийн хамгийн их буюу 44%-ийг бүрдүүлж байна. Харин Афганистан, Испани, Итали, Канад, Пакистан, Шинэ Зеланд зэрэг улсын сувгууд тус бүр 1 бүртгэгдсэн нь хамгийн бага буюу 0.3%-ийг эзэлж байна.

Орон нутгийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн дундаас хамгийн их гадаадын телевизийн сувгийг хэрэглэгчдэд хүргэж байгаа нь ЖСММ “БГБХ” Нөхөрлөл байна. Тус байгууллага нийт 50 гадаад суваг дамжуулж байгаа нь орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн дамжуулж буй гадаад сувгийн 17 %-ийг эзэлж байна. Энэ нь тухайн компанийн техникийн хүчин чадал, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Харин хамгийн бага гадаад суваг дамжуулж буй нь “Орхон систем” ХХК бөгөөд тэд зөвхөн 7 суваг дамжуулж, орон нутгийн нийт дамжуулалтын 2.4%-ийг бүрдүүлсэн. Энэ нь тухайн бүс нутгийн хэрэглэгчийн тоо, зах зээлийн хэмжээ, дамжуулах сүлжээний хүчин чадал, сувгийн эрх авахтай холбоотой зардлын нөлөө зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалсан байх магадлалтай байна.


Хүснэгт-4:Орон нутгийн ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгуудыг харьяалагдах улсаар нь харуулав.

№	Харьяалагдах улс	Орон нутаг														Нийт	
		Агаарын суваг ХХК	Би Ти Жи ХХК	Гал саятан ХХК	Дархан ширхэнцэг ХХК	Ди Би Эс Си ХХК	Дөрвөн шарга ХХК	ЖСММ БГБХ Нөхөрлөл	Мөнх саран чулуун ХХК	Мэргэшир-Од ХХК	Наран гүрт ХХК	Орхон систем ХХК	Өвөр даваат ХХК	Хаан алтай ховд ХХК	Цацраг трейд ХХК		Эм Эм Ди Эс ХХК
1	Афганистан		1														1
2	Англи				1		3	1						3	1		9
3	АНУ	1	1	4			1	4	1	2	1	1		2			18
4	БНКУ	1				1		19	1				1	4	1		28
5	БНСУ		1	1	1			1		1			1		1	1	8
6	БНХАУ		2		4	2		2	3	1		1	5	2	8	3	33
7	Герман	2			1					1	1		1	1	1	1	9
8	Испани												1				1
9	Итали												1				1
10	Их Британи		1					3		1	1			3			9
11	Канад													1			1
12	Катар	1								1						1	3
13	Нидерланд	1					1										2
14	ОХУ	8	3	8	6	4	36	19	3	4	3	5	2	14	7	4	126
15	Пакистан															1	1
16	Турк					2				1					1		4
17	Франц				1	2			1	1			2	1	1	1	10
18	Хонг Конг		1			1				1							3
19	Швед	4					1	1						2			8
20	Шинэ Зеланд				1												1
21	Энэтхэг									1	2						3
22	Япон	1							1	1	1			1	1	1	7
Нийт		19	10	13	15	12	42	50	10	16	9	7	14	34	22	13	286

Нийт дүнгээр авч үзвэл орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн гадаад суваг дамжуулах хэмжээ ихээхэн ялгаатай байгаа нь бүс нутгийн хэрэглэгчдэд хүрэх телевизийн олон улсын контентын хүртээмж, төрөлжилт харилцан адилгүй байгааг харуулж байна.

Орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн дамжуулж буй гадаад сувгийн тоо 2024 онд 322 байсан бол 2025 онд 286 болж, 36 сувгаар буюу 11%-иар буурсан. Энэ бууралтад голлон нөлөөлсөн хүчин зүйл нь орон нутгийн хоёр үйлчилгээ эрхлэгч өөрийн хүсэлтээр тусгай зөвшөөрлөө хүчингүй болгосон, түүнчлэн Дөрвөн шарга ХХК болон Хаан Алтай Ховд ХХК тус бүр гадаадын 6 сувгийг цөөлсөн нь нийт сувгийн тоо багасахад нэмж нөлөөлсөн байна.

График-5. Орон нутгийн ҮЭ-ийн дамжуулж буй гадаадын телевизийн сувгийг 2024 оны тоон мэдээлэлтэй харьцуулсан дүн.



3.1. ГАДААД СУВГИЙН ХАРЬАЛАХ УЛС:

Хүснэгт-5-д өгөгдсөн тоон мэдээллээс харахад 2024 онд Сингапур улсын телевизийн 24 суваг бүртгэгдсэн бол 2025 онд 40 болж, 16 суваг нэмэгдэн ойролцоогоор 66%-иар өссөн үзүүлэлттэй байна. Харин АНУ-ын хувьд 22 суваг хасагдаж, нийт 63 суваг бүртгэгдсэн нь 25%-ийн бууралтыг илэрхийлж байна.

Гадаад сувгийн 2025 оны тайланд ОХУ-ын 13 телевизийн суваг хасагдаж, 264 суваг бүртгэгдсэн хэдий ч ОСДҮЭ-ийн хамгийн их дамжуулж буй улсын телевизийн суваг хэвээр байна. Энэ нь нийт гадаад сувгийн 36%-ийг бүрдүүлж, сувгийн нийлүүлэлтийн томоохон хувь нь ОХУ-ын сувгуудаас бүрдэж буйг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, бусад улсын сувгийн тоо өөрчлөгдсөн ч, ОХУ нь олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн дунд хамгийн өргөн тархсан, хэрэглэгчдэд хамгийн түгээмэл сонголт болж байна.

ОХУ-ын телевизийн сувгийн нийлүүлэлт хамгийн их байгаагийн шалтгаан нь хиймэл дагуулын үнэгүй (FTA – Free-to-Air) сувгуудын тоо их байгаагаар холбоотой. Эдгээр сувгууд нь ямар ч захиалгагүй, төлбөр төлөхгүйгээр шууд дамжуулалт хүлээн авах боломжтой учраас олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд (ОСДҮЭ) түгээмэл

ашиглагддаг. Ингэснээр ОХУ-ын телевизийн сувгууд олон улсын зах зээлд өргөн тархаж, нийт гадаад сувгийн дийлэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт-5: Орон нутгийн ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгуудыг харьяалагдах улсаар нь 2024 оны тоон мэдээлэлтэй харьцуулахад.

№	Харьяалагдах улс	2024	2025	Өсөлт/бууралт /сувгийн тоогоор/
1	Афганистан	1	1	-
2	Австрали	3	2	▼1
3	Англи	15	13	▼2
4	АНУ	85	63	▼22
5	Араб	2	2	-
6	БНКУ	42	47	▲5
7	БНСУ	29	26	▼3
8	БНХАУ	82	73	▼9
9	Болгар	5	4	▼1
10	Вьетнам	-	1	-
11	Герман	26	23	▼3
12	Испани	5	3	▼2
13	Итали	6	4	▼2
14	Их Британи	28	32	▲4
15	Канад	5	6	▲1
16	Катар	9	9	-
17	Киргизстан	4	3	▼1
18	Люксембург	1	1	-
19	Нидерланд	7	5	▼2
20	ОХУ	277	264	▼13
21	Пакистан	1	1	-
22	Сингапур	24	40	▲16
23	Словак	3	3	-
24	Турк	5	5	-
25	Украйн	2	3	▲1
26	Унгар	1	-	-
27	Франц	38	40	▲2
28	Хонг Конг	4	7	▲3
29	Чех	3	1	▼2
30	Швед	17	14	▼3
31	Шинэ Зеланд	8	7	▼1
32	Энэтхэг	4	5	▲1
33	Япон	18	19	▲1
Нийт		760	727	▼33

График-6. ОСДҮЭ-ийн сүлжээгээр хамгийн их дамжиж байгаа гадаад сувгуудын харьяалах улс орныг нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд.





График-7. ОСДҮЭ-ийн сүлжээгээр хамгийн бага дамжиж байгаа гадаад сувгуудын харьяалах улс орныг нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд.



Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр хамгийн их дамжиж байгаа гадаад сувгуудын хувьд: 2025 оны тайланд давхардаагүй тоогоор 287 гадаадын суваг бүртгэгдсэн бөгөөд дамжуулалтын давтамж хамгийн өндөр буюу олон үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжиж байгаа дараах 14 телевизийн суваг бүртгэгдсэн. Үүнээс 6 нь ОХУ-ын телевизийн сувгууд байна. Тухайлбал, “Первый канал”, “Карусель”, “НТВ”, “РЕН ТВ”, “Матч” болон “Звезда” зэрэг сувгууд нь 8-18 үйлчилгээ эрхлэгчээр дамжин үзэгчдэд хүрч байна.

Хүснэгт-6: ОСДҮЭ-ийн сүлжээгээр хамгийн их дамжиж байгаа гадаадын 14 телевизийн сувгийн мэдээллийг хүснэгтээр үзүүлэв.

№	Сувгийн нэр	Гадаад сувгийн харьяалагдах улс	Сувгийн төрөлжилт	Дамжуулж буй үйлчилгээ эрхлэгчдийн тоо
1	Первый канал	ОХУ	Олон талт хөтөлбөртэй	18
2	DW English	Герман	Мэдээний	17
3	Карусель	ОХУ	Хүүхдийн	16
4	НТВ	ОХУ	Олон талт хөтөлбөртэй	12
5	TV5 Monde	Франц	Олон талт хөтөлбөртэй	11
6	РЕН ТВ	ОХУ	Олон талт хөтөлбөртэй	11
7	Матч	ОХУ	Спорт	10
8	Cartoon Network	АНУ	Хүүхдийн	9
9	Aljazeera	Катар	Мэдээний	9
10	Fashion TV	Франц	Загвар	8
11	NHK WORLD	Япон	Мэдээний	8
12	Звезда	ОХУ	Танин мэдэхүй	8
13	CGTN	БНХАУ	Мэдээний	8
14	Airang	БНСУ	Олон талт хөтөлбөртэй	8

Гадаад сувгийн 2024 оны тайлангаар “Первый канал” нь 21 үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжин хамгийн өндөр нийлүүлэлттэй сувагт тооцогдож байсан. Харин 2025 онд гурван үйлчилгээ эрхлэгч тухайн сувгийг дамжуулахаа зогсоосноор дамжуулалтын тоо 18 болж буурсан ч тус суваг нь гадаад сувгуудаас хамгийн олон сүлжээгээр үзэгчдэд хүрсээр байна.

Харин 27 улсын 160 телевизийн суваг хамгийн бага буюу 1 ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж өмнөх оныхоос 23 сувгаар өссөн байна. Ингэснээр нэг үйлчилгээ эрхлэгчээр дамждаг сувгуудын тоо нэмэгдэж байгаа нь гадаад контентын төрөлжилт, үзэгчдийн сонирхлын цар хүрээ өргөжин тэлж байгааг харуулж байна.


3.2. ГАДААД СУВГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛ:

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжиж буй гадаадын телевизийн сувгийн хөтөлбөрүүдийн хэлний төрлийг судалж үзэхэд Орос хэлээр дамждаг сувгууд хамгийн их хувийг (291 суваг) эзэлж, нийт гадаад сувгийн ойролцоогоор 40%-ийг бүрдүүлж байна. Энэ нь Монгол Улсад орос хэлээр үзэгчдэд чиглэсэн контентын эрэлт хэрэгцээ өндөр, мөн Орос хэл дээрх олон улсын телевизийн сүлжээ өргөн хүрээнд хүрч байгааг илтгэж байна. Харин Болгар, Унгар улсын болон хятад/өвөр монгол, англи/итали/орос зэрэг хосолсон хэлээр нэвтрүүлдэг телевизийн сувгийн тоо хамгийн бага буюу 1 суваг байна. Энэ нь нийт гадаад сувгийн ердөө 0.14%-ийг эзэлж байна.

Хүснэгт-7: ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгуудыг хэлний төрлөөр нь ангилсан байдал.

Хөтөлбөрийн хэл	Орос	Англи	Хятад	Казах	Солонгос	Франц	Орос/Англи	Өвөр Монгол	Япон	Орос/Казах	Герман	Хинди	Араб	Итали	Турк	Испани	Герман/Англи	Англи/Итали/Орос	Болгар	Унгар	Хятад, Өвөр Монгол
Сувгийн тоо	291	229	48	33	21	19	16	13	13	9	6	6	5	4	4	3	2	1	1	1	1
Нийт сувагт эзлэх хувь	40.03%	31.50%	6.60%	4.54%	2.89%	2.61%	2.20%	1.79%	1.79%	1.24%	0.83%	0.83%	0.69%	0.55%	0.55%	0.41%	0.28%	0.14%	0.14%	0.14%	0.14%

График-8: ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгуудыг хэлний төрлөөр нь нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд.



3.3. ГАДААД СУВГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТӨРӨЛ:

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжиж буй гадаадын телевизийн сувгийг хөтөлбөрийн төрлөөр нь ангилан үзвэл олон талт хөтөлбөртэй сувгууд хамгийн их буюу 158 суваг бүртгэгдсэн байна. Энэ нь нийт гадаад сувгийн 21.73%-ийг эзэлж байгаа нь олон төрлийн мэдээ, соёл, спорт, боловсрол, үзвэр зэрэг олон чиглэлийн агуулгыг хамарсан контент үзэгчдийн эрэлт хэрэгцээ их байгааг илтгэж байна.


Газар нутгийн байршлаар нь авч үзэхэд: Улаанбаатар хотын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нийт олон талт хөтөлбөртэй 90 телевизийн суваг дамжуулж байгаа бөгөөд энэ нь нийслэлийн үзэгчдэд зориулсан өргөн сонголт, төрөл бүрийн контентын хүртээмж илүү байгааг харуулж байна. Харин орон нутгийн үйлчилгээ эрхлэгчид нийт 68 суваг дамжуулж байгаа нь хөдөө, орон нутагт амьдарч буй үзэгчид ч олон талт хөтөлбөртэй гадаад сувгаар тогтвортой хангагдаж байгааг илтгэж байна.

“Тел худалдаа”-ны чиглэлээр нэвтрүүлэг бэлтгэн дамжуулдаг гадаадын телевизүүд нь 1 байгаа нь хамгийн бага буюу нийт гадаад сувгийн 0.1%-ийг бүрдүүлж байна.

Хүснэгт-8: Гадаад сувгийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд.

Үйлчилгээ эрхлэгчийн нэр		Хөтөлбөрийн төрөл																	Нийт
		Амьдралын хэв маяг, Соёл	Ан, амьтан	Аялал жуулчлал	Баримтат	Боловсрол	Дуу, хөгжим	Загвар	Зугаа цэнгэл	Кино	Мэдээний	Насанд хүрэгчдэд	Нийгэм, эдийн засаг	Олон талт хөтөлбөртэй	Спорт	Танин мэдэхүй	Тел худалдаа	Хүүхдийн	
Улаанбаатар	Ддэш ТВ ХХК	6	2	1	2		3		1	8	6	1		8	1	3		9	51
	Мобинет ХХК				2		4			8	5			8	1	2		6	36
	Монголсат нэтворкс ХХК	1					1		6	3	6	1		2	2	3		3	28
	Монголын цахилгаан холбоо ХХК	1	2		1	1			1	4	2			6	4	4		2	28
	Оптимум нэтворкс ХХК	1			1		1		1		4		1	9	1			1	20
	Сансар дижитал ХХК		1					1		2	6			8	2	1		2	23
	Скаймедиа корпораци ХХК	2	1		3	1	3	1	6	4	15			13	1	6		9	65
	Талс эрчим ХХК		2		1	1			1	2				6	4	8		2	27
	Шинэ сансар ХХК	1					3		1	2	8		2	9	1	3		3	33
	Эн Би Си ХХК	2			3			1	5	7	10			8	5	1		6	48
	Юнивишн ХХК	8	2	1	6		4	1	6	8	11	1	3	13	2	6		10	82
Орон нутаг	Агаарын суваг ХХК	1	1			1			1	1	2			4	4	2		2	19
	Би Ти Жи ХХК						1		1	2	1		1	3				1	10
	Гал саятан ХХК				1		1	1	2	1	1			3	2			1	13
	Дархан ширхэнцэг ХХК							1		1	3			6	2			2	15
	Ди Би Эс Си ХХК	1			1		1	1					1	5				2	12
	Дөрвөн шарга ХХК	3	2			1	2		6	6	3			7	3	5	1	3	42
	ЖСММ БГБХ Нөхөрлөл	3		1		1	2		1	7	4			9	9	11		2	50
	Мөнх саран чулуун ХХК	1							1	1	1		1	2	1	1		1	10
	Мэргэшир-Од ХХК	1					1		1		4			4	2	2		1	16
	Наран гүрт ХХК				1		1			1	1			1	1	1		2	9
	Орхон систем ХХК										6			1					7
	Өвөр даваат ХХК							1	1	3	1			4	1	1		2	14
	Хаан алтай ховд ХХК		2	1	1	1	1	1	3	5	3			9	1	3		3	34
	Цацраг трейд ХХК				1			1	1	2	5		1	6	1	3		1	22
	Эм Эм Ди Эс ХХК	1					1			2	3			4		1		1	13
	Нийт	33	15	4	24	7	30	10	46	80	111	3	10	158	51	67	1	77	727

График-9: ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгуудыг хөтөлбөрийн төрлөөр нь нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд.



3.4. ОСДҮЭ-ИЙН ГАДААД СУВГИЙН ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ:

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр 727 гадаадын телевизийн суваг дахин дамжуулж байгаагийн дотор зөвхөн 278 суваг нь гэрээний үндсэн дээр дамжуулагдаж байна. Энэ нь нийт гадаад сувгийн ердөө 38%-ийг л хамарч байгаа бол үлдсэн 449 суваг буюу 62% нь суваг дамжуулах гэрээ байгуулаагүйгээр дамжуулагдаж байна.


Гэрээний байдалд үйлчилгээ эрхлэгчдийн хооронд томоохон зөрүү ажиглагдаж байна. Үүнд:

- 2 үйлчилгээ эрхлэгч өөрийн сүлжээгээр дамжуулж байгаа гадаадын бүх сувгаа 100% гэрээтэйгээр дамжуулж байгаа нь эерэг жишээ боловч, нийт үйлчилгээ эрхлэгчдийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад энэ нь салбарын хэмжээнд хангалттай түвшинд хүрээгүй байна.
- 8 үйлчилгээ эрхлэгч зарим гадаад сувгийнхаа хувьд гэрээ байгуулсан ч, бүх сувгаа хамарсан бүрэн эрхийн зохицуулалтгүй тул зөвхөн хэсэгчилсэн гэрээтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.
- Улаанбаатар хотын 3, орон нутгийн 13 үйлчилгээ эрхлэгч нь гадаадын телевизийн сувгийг ямар нэгэн гэрээгүйгээр дахин дамжуулж байгаа нь гэрээгүй сувгийн тоо өндөр хэвээр байх гол хүчин зүйл болсон байна.

Хүснэгт-9: ОСДҮЭ-ийн гадаад сувгийн гэрээний талаарх мэдээлэл.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Гадаад сувгийн тоо	Гэрээтэй сувгийн тоо	Гэрээгүй сувгийн тоо
Улаанбаатар				
1	Шинэ сансар кабель ХХК	33	19	14
2	Монголын цахилгаан холбоо ХК	28	-	28
3	Сансар Дижитал ХХК	23	4	19
4	Эн Би Си ХХК	48	33	15
5	Талст эрчим ХХК	27	-	27
6	Оптимум нэтворк ХХК	20	-	20
7	Юнивишн ХХК	82	82	-
8	Скаймедиа корпораци ХХК	65	4	61
9	ДДэш ТВ ХХК	51	48	3
10	Монголсат нэтворкс ХХК	28	28	-
11	Мобинет ХХК	36	35	1
Орон нутаг				
1	Эм Эм Ди Эс ХХК	13	-	13
2	ЖСММ БГБХ Нөхөрлөл	50	19	31
3	Ди Би Эс Си ХХК	12	-	12
4	Мөнх саран чулуу ХХК	10	6	4
5	Мэргэшир-од ХХК	16	-	16
6	Цацраг трейд ХХК	22	-	22
7	Өвөр даваат ХХК	14	-	14
8	Агаарын суваг ХХК	19	-	19
9	Дархан ширхэнцэг ХХК	15	-	15
10	Орхон системс ХХК	7	-	7
11	Гал саятан ХХК	13	-	13
12	Би Ти Жи ХХК	10	-	10
13	Дөрвөн шарга ХХК	42	-	42
14	Хаан Алтай Ховд ХХК	34	-	34
15	Наран гүрт ХХК	9	-	9
Нийт		727	278	449

График-10. Гэрээтэй болон гэрээгүй гадаад сувгийн тоог хувиар илэрхийлбэл.



Дүгнэлт

Гадаад сувгийн 2025 оны бүртгэлийн тайланд нийт 26 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр 32 улсын 727 гадаадын телевизийн суваг дамжуулагдаж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 33 сувгаар буурч, 4%-ийн буурсан үзүүлэлттэй байна. Бууралтад үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлөө хүчингүй болгосон шийдвэр, гэрээ дуусгавар болсон болон сувгийн нийлүүлэлт тасарсан зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.

Гадаад сувгийн харьяаллын бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан ба АНУ-ын сувгуудын тоо 25%-иар буурч 63 болж, харин Сингапур улсын сувгууд 66%-иар өсөж 40 болж нэмэгдсэн. Мөн Вьетнам улсын суваг шинээр бүртгэгдэж, Унгар улсын суваг бүртгэлээс хасагдсан байна.

Технологийн хувьд SD сувгийн эзлэх хувь буурч, харин HD сувгийн тоо 201 болж өссөн нь хэрэглэгчид илүү өндөр чанартай дүрс, дуу шаарддаг болсон зах зээлийн эрэлттэй уялдаж байна.

Гэрээний хэрэгжилтийн түвшин сул байгаа бөгөөд нийт сувгийн 38% нь гэрээтэй, харин 62% нь гэрээгүй дамжуулагдаж байна. Энэ нь зохиогчийн эрх болон бүтээл ашиглалтын зөвшөөрөлтэй холбоотой тодорхой эрсдэлийг дагуулж, цаашид хууль зүйн маргаан үүсэх боломжтойг харуулж байна.

Харин ОХУ-ын телевизийн сувгууд 264 бүртгэгдсэнээр нийт гадаад сувгийн 36%-ийг эзэлж, хамгийн том нийлүүлэгч хэвээр байгаа нь онцлог бөгөөд энэ нь төлбөргүй (FTA) сувгийн өргөн хэрэглээтэй холбоотой юм.

Эдгээр өөрчлөлт, төлөв нь бүс нутгийн эрэлт, технологийн шинэчлэл болон гэрээний хэрэгжилттэй шууд хамааралтай тул үйлчилгээ эрхлэгчид сувгийн бүтцээ хэрэглэгчийн эрэлт ба бүс нутгийн чиг хандлагад нийцүүлэн оновчтой төлөвлөх, мөн гэрээний хамрах хүрээг өргөтгөх шаардлагатай байна.